

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ

ДАХИН ОЛГОХ ДАРААЛАЛ

1. **WWW.MCIS.GOV.MN** сайтад хандаж Тусгай зөвшөөрөл “цэс”-ний “Холбогдох баримт бичиг” хэсгээс **СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА**-тай танилцах, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”, Барилгын тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагатай танилцах
2. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь төрийн мэдээллийн сангуудтай холбогдсон тул тус цахим программд бүртгүүлэх инженер, техникийн ажилтнууд **E-Mongolia** платформд бүртгүүлсэн байх
3. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн **ГЭРЧИЛГЭЭГ ГЭЭСЭН, ҮРЭГДҮҮЛСЭН** шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргах бол дээр дурдсан 1, 2-т заасан мэдээллийг цахим системд бүртгүүлэхээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ.
Үүнд:
 - Албан хүсэлт
 - Гэрчилгээг гээсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулсан хуулбар
 - ААНБ-ууд нь үйл ажиллагааны тайлан мэдээгээ БХТ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэст хагас жил тутам илгээж, БҮАТЗ-ийн хавсралтад тэмдэглэл хийлгэсэн байх БҮАТЗ авснаас хойш гүйцэтгэсэн ажлын тайланг /www.mcis.gov.mn сайтад гүйцэтгэсэн ажлын тайлан хэсэгт ажлын гэрээг хавсаргах, БҮАТЗ авснаас хойшхи хугацаанд шимтгэл төлсөн баримтын хуулбарыг хавсаргах, Барилгын норм, норматив боловсруулах сангийн шимтгэлийг /төсөвт өртгийн 0,18 хувиар/ төлсөн байна.
 - Тусгай зөвшөөрөлтэй заалтуудад хамаарах инженерийн техникийн ажилчдаа бүртгүүлсэн байна.
4. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн **ОНООСОН НЭР, ЭЗЭМШИГЧИЙН НЭР ӨӨРЧЛӨГДСӨН** шалтгаанаар тусгай зөвшөөрлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах бол дээр дурдсан 1, 2-т заасан мэдээллийг цахим системд бүртгүүлэхээс гадна бол дор дурдсан баримт бичгийг дээр дурдсан 1, 2-т заасан мэдээллийг цахим системд бүртгүүлэхээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ.
Үүнд:
 - Улсын бүртгэлийн газрын лавлагаа
 - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - Хуулийн этгээдийн дүрмийн хуулбар
 - Эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

- ААНБ-ууд нь үйл ажиллагааны тайлан мэдээгээ БХТ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэст хагас жил тутам илгээж, БҮАТЗ-ийн хавсралтад тэмдэглэл хийлгэсэн байх БҮАТЗ авснаас хойш гүйцэтгэсэн ажлын тайланг /www.mcis.gov.mn сайтад гүйцэтгэсэн ажлын тайлан хэсэгт ажлын гэрээг хавсаргах, БҮАТЗ авснаас хойшхи хугацаанд шимтгэл төлсөн баримтын хуулбарыг хавсаргах, Барилгын норм, норматив боловсруулах сангийн шимтгэлийг /төсөвт өртгийн 0,18 хувиар/ төлсөн байна.
- Тусгай зөвшөөрөлтэй заалтуудад хамаарах инженерийн техникийн ажилчдаа бүртгүүлсэн байна.

5. **БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС (420 000 төгрөг)**
төлсөн төлбөрийн баримт хавсаргах

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХЭЛТЭС
УТАС: 70165055, 70185055